



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

МОНГОЛЫН ЦАХИЛГААН ХОЛБОО ХК-ИЙН 2025 ОНЫ САНХҮҮГИЙН  
ТАЙЛАНД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН КОД: САГ-2026/54/НА-СТА-ТӨҮГ

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг  
дараах хаягаар авна уу.



Санхүүгийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор  
Ц.Наранчимэг  
Утас: 51-261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn  
Аудитын менежер: П.Чанцалдулам  
Утас: 260949 Цахим хаяг: chantsaldulamp@audit.gov.mn  
Ахлах аудитор: Д.Мөнхжин  
Утас: 261628 Цахим хаяг: munkhjind@audit.gov.mn  
Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: Ниямазон аудит ХХК-ийн  
захирал З.Цээнээ  
Утас: 70145906 Цахим хаяг: audit@nmz.mn

Улаанбаатар хот  
2026 он



## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

Засгийн газрын IV байр, Бага тойруу 3,  
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160  
Утас: 26 04 37, Факс: (976-51) 26 42 30,  
Цахим шуудан: info@audit.gov.mn,  
Цахим хуудас: www.audit.mn

2026.03.30 № 06/856  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

МОНГОЛЫН ЦАХИЛГААН ХОЛБОО  
ХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ  
Б.ЧИНБАТ ТАНАА

### Аудитын тайлан хүргүүлэх тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу төрийн өмчит, төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болсон санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан, гэрчилгээг хүргүүлж байна.

Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийг арилгах арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д “Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ.” гэж заасны дагуу Үндэсний аудитын газарт ирүүлж, биелэлтийг ханган ажиллахыг зөвлөж байна.

Аудитаар тогтоосон төлбөрийн акт, хүргүүлсэн албан шаардлага, өгсөн зөвлөмжийг хугацаанд нь биелүүлээгүй бол Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1-д “Энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно”, 42.2-т “Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайланд дүгнэлт өгөхөөс татгалзсан, энэ хуулийн 20.5-д заасан төлөвлөгөөг ирүүлээгүй нь тухайн албан хаагчийг ажлаас халах сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно” гэж тус тус заасныг анхаарч ажиллана уу.

Хавсралт .... хуудаастай.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

АГУУЛГА

1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ .....	3
2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН .....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	5
2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан .....	6
2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан .....	7
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан .....	8
2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл .....	10
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА .....	12
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа .....	12
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин .....	12
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....	13
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого ба толилуулгад орсон өөрчлөлт .....	13
3.5 Зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл .....	14
4. АУДИТЫН ТАЙЛАН .....	16
4.1 Ерөнхий зүйл .....	16
4.2 Материаллаг байдал .....	16
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт .....	16
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	16
4.5 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн .....	18
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал .....	18
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ .....	19
5.1 Төлбөрийн акт .....	19
5.2 Албан шаардлага .....	20
5.3 Зөвлөмж .....	21
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ .....	22
Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл .....	22
Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл .....	23
Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	24

**Товчилсон үгийн жагсаалт**

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
НА	Нотлох ажил
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
НӨАТ	Нэмэгдсэн өртгийн албан татвар
САГ	Санхүүгийн аудитын газар
ТӨҮГ	Төрийн өмчит үйлдвэрийн газар
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар
ТӨХХК	Төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компани
ТУЗ	Төлөөлөн удирдах зөвлөл
ХК	Хувьцаат компани
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ХЭХ	Хувьцаа эзэмшигчдийн хурал



## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

Засгийн газрын IV байр, Бага тойруу 3,  
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160  
Утас: 26 04 37, Факс: (976-51) 26 42 30,  
Цахим шуудан: info@audit.gov.mn,  
Цахим хуудас: www.audit.mn

МОНГОЛЫН ЦАХИЛГААН ХОЛБОО  
ХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ  
Б.ЧИНБАТ ТАНАА

2026.03.16 № 06/714  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

### Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Монголын цахилгаан холбоо ХК-ийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан болон нягтлан бодох бүртгэлийн бодлого, тайлбар тодруулгаас бүрдсэн санхүүгийн тайланд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх орлогын дэлгэрэнгүй, мөнгөн гүйлгээг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

### Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын олон улсын стандарт (АОУС), түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу хараат бусаар гүйцэтгэж, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн дараах залруулагдаагүй 327.1 сая төгрөгийн зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 68.8 сая төгрөгөөр давсан бөгөөд дангаараа болон нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй байна. Тухайлбал;

- Арваас дээш жилийн насжилттай 129.1 сая төгрөгийн авлага барагдуулах арга хэмжээ аваагүй;
- Жижиг мөнгөн сангийн гүйлгээний хязгаарыг 96.3 сая төгрөгөөр хэтрүүлэн зарцуулсан;
- ТУЗ-ийн гишүүдэд 45.4 сая төгрөгийн цалин, хөлс илүү олгосон;
- Зориулалт тодорхой бус, анхан шатны баримтын бүрдэлгүй 37.2 сая төгрөг зарцуулсан.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1, 13.3, 13.4, 13.7, 18 дугаар зүйлийн 18.1, 20 дугаар зүйлийн 20.2.5, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 1.3, Нийгмийн даатгалын сангаас олгох

Z:\Yawsan\_Bichig\2026\0316 SAG-59.Docx

1526141207

тэтгэмжийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1, Компанийн тухай хуулийн 83 дугаар зүйлийн 83.1-т заасантай тус тус нийцээгүй, санхүүгийн тайлагналын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

### **Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг**

Улсын Их Хурлаар 2025 оны намрын ээлжит чуулганаар хэлэлцсэн “Төрийн өмчит хуулийн этгээдийн хувьцааг 2026-2028 онд биржээр олон нийтэд нээлттэй худалдах, төрийн өмчийг хувьчлах, өөрчлөн байгуулах үндсэн чиглэл батлах тухай” тогтоолын төсөлд Монголын цахилгаан холбоо ХК-ийн энгийн хувьцааг нэмж гарган, биржээр олон нийтэд нээлттэй худалдахаар тусгажээ. Монголын хөрөнгийн биржээр 2025 онд 109 өдөр 14,215 ширхэг нийт 9.7 сая төгрөгийн хувьцааны арилжаа явагдсан байна.

### **Аудитын гол асуудал**

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн гол чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Нягтлан бодох бүртгэлийн програм хангамжийг 2024 онд сонгон шалгаруулж, 2025 онд Ординат ХХК-ийн нийлүүлсэн Юникус програмыг ашиглан санхүүгийн тайланг бэлтгэсэн бөгөөд шинэ системд шилжсэнтэй холбоотойгоор зарим дансны ангилал, кодчлолын алдаа гарч, дансны тохиргоо бүрэн оновчтой хийгдээгүй байна.

### **Бусад асуудлын хэсэг**

Төрийн аудитын байгууллага нь АДБОУ-ын стандартын дагуу аудитын мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээ буюу өмнөх аудитаар өгсөн аудитын шийдвэрийн хэрэгжилтийг хянаж, үнэлэх үүрэг хүлээдэг. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

### **Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага**

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2024 оны 12 дугаар сарын 31	2025 оны 12 дугаар сарын 31
<b>1</b>	<b>ХӨРӨНГӨ</b>		
<b>1.1</b>	<b>Эргэлтийн хөрөнгө</b>		
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	484,906,162.75	155,508,788.12
1.1.2	Дансны авлага	6,847,874,274.85	3,625,488,303.47
1.1.3	Татвар, НДШ-ийн авлага	11,690,176.25	25,717,964.99
1.1.4	Бусад авлага	1,587,390,879.12	2,114,936,511.09
1.1.6	Бараа материал	3,212,389,509.63	2,651,363,151.03
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	3,788,503,981.63	1,283,718,556.27
1.1.11	<b>Эргэлтийн хөрөнгийн дүн</b>	<b>15,932,754,984.23</b>	<b>9,856,733,274.98</b>
<b>1.2</b>	<b>Эргэлтийн бус хөрөнгө</b>		
1.2.1	Үндсэн хөрөнгө	38,303,984,017.64	38,753,685,386.84
1.2.2	Биет бус хөрөнгө	10,024,622,061.59	10,146,117,842.55
1.2.4	Урт хугацаат хөрөнгө оруулалт	166,530,700.63	142,519,443.63
<b>1.2.10</b>	<b>Эргэлтийн бус хөрөнгийн дүн</b>	<b>48,495,136,779.86</b>	<b>49,042,322,673.02</b>
<b>1.3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>64,427,891,764.09</b>	<b>58,899,055,948.00</b>
<b>2</b>	<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ</b>		
<b>2.1</b>	<b>Өр төлбөр</b>		
<b>2.1.1</b>	<b>Богино хугацаат өр төлбөр</b>		
2.1.1.1	Дансны өглөг	6,288,431,914.57	3,200,885,186.03
2.1.1.3	Татварын өр	1,860,381,683.90	1,436,707,634.40
2.1.1.4	НДШ-ийн өглөг	184,432.26	6,113,429.01
2.1.1.7	Ноогдол ашгийн өглөг	154,365,413.66	153,091,625.61
2.1.1.8	Урьдчилж орсон орлого	366,847,275.06	287,841,031.14
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр	4,050,346,519.30	2,716,825,269.46
<b>2.1.1.13</b>	<b>Богино хугацаат өр төлбөрийн дүн</b>	<b>12,720,557,238.75</b>	<b>7,801,464,175.65</b>
<b>2.1.2</b>	<b>Урт хугацаат өр төлбөр</b>		
2.1.2.3	Хойшлогдсон татварын өр	1,503,973,693.32	1,503,973,693.32
2.1.2.4	Бусад урт хугацаат өр төлбөр	1,265,024,580.52	1,127,055,955.09
<b>2.1.2.6</b>	<b>Урт хугацаат өр төлбөрийн дүн</b>	<b>2,768,998,273.84</b>	<b>2,631,029,648.41</b>
<b>2.2</b>	<b>Өр төлбөрийн нийт дүн</b>	<b>15,489,555,512.59</b>	<b>10,432,493,824.06</b>
<b>2.3</b>	<b>Эздийн өмч</b>		
2.3.1	Өмч:-төрийн	2,449,928,700.00	2,449,928,700.00
2.3.2	-хувийн	137,098,889.00	137,098,889.00
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	14,088,188,462.23	14,088,188,462.23
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг	8,247,270,172.39	8,247,270,172.39
2.3.9	Хуримтлагдсан ашиг	24,015,850,027.88	23,544,075,900.32
<b>2.3.11</b>	<b>Эздийн өмчийн дүн</b>	<b>48,938,336,251.50</b>	<b>48,466,562,123.94</b>
<b>2.4</b>	<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН</b>	<b>64,427,891,764.09</b>	<b>58,899,055,948.00</b>

## 2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2024 оны 12 дугаар сарын 31	2025 оны 12 дугаар сарын 31
1	Борлуулалтын орлого (цэвэр)	25,097,594,083.63	18,825,283,426.45
2	Борлуулалтын өртөг	19,628,981,359.43	12,617,243,803.76
3	<b>Нийт ашиг( алдагдал)</b>	<b>5,468,612,724.20</b>	<b>6,208,039,622.69</b>
4	Түрээсийн орлого	534,370,170.83	768,627,150.08
5	Хүүний орлого	68,102,080.28	1,818,284.98
8	Бусад орлого	164,732,631.72	266,977,908.27
9	Борлуулалт, маркетингийн зардал	1,123,680,670.16	2,236,073,324.39
10	Ерөнхий ба удирдлагын зардал	3,057,167,663.25	4,271,056,766.46
11	Санхүүгийн зардал	1,185,265,879.95	650,484,122.57
12	Бусад зардал	833,192,215.99	47,160,162.39
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	(371,088.35)	(2,346,998.77)
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	71,842,077.80	-
18	<b>Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)</b>	<b>107,982,167.13</b>	<b>38,341,591.44</b>
19	Орлогын татварын зардал	49,306,373.81	30,145,088.26
20	<b>Татварын дараах ашиг (алдагдал)</b>	<b>58,675,793.32</b>	<b>8,196,503.18</b>
22	<b>Тайлант үеийн цэвэр ашиг ( алдагдал)</b>	<b>58,675,793.32</b>	<b>8,196,503.18</b>
24	<b>Орлогын нийт дүн</b>	<b>58,675,793.32</b>	<b>8,196,503.18</b>
25	<b>Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдалтай)</b>	<b>58,675,793.32</b>	<b>8,196,503.18</b>

### 2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний дуусвар болсон

№	Үзүүлэлт	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	2023 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	2,587,027,589.00	14,088,188,462.23	8,247,270,172.39	25,445,254,001.61	50,367,740,225.23
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга				(1,488,079,767.05)	1,488,079,767.05
4	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)				58,675,793.32	58,675,793.32
9	2024 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	2,587,027,589.00	14,088,188,462.23	8,247,270,172.39	24,015,850,027.88	48,938,336,251.50
10	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга				(479,970,630.74)	(479,970,630.74)
12	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)				8,196,503.18	8,196,503.18
17	2025 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	2,587,027,589.00	14,088,188,462.23	8,247,270,172.39	23,544,075,900.32	48,466,562,123.94

/төгрөгөөр/

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2024 оны 12 дугаар сарын 31	2025 оны 12 дугаар сарын 31
<b>1</b>	<b>Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	23,578,409,128.05	20,177,363,839.95
	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	17,064,339,500.91	18,348,271,383.70
	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	872,778.00	-
	Бусад мөнгөн орлого	6,513,196,849.14	1,829,092,456.25
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	20,546,346,736.77	18,694,989,455.32
	Ажиллагчдад төлсөн	6,647,911,351.92	7,407,686,789.51
	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	1,880,547,081.74	2,076,617,056.58
	Бараа материал худалдан авахад төлсөн	3,929,480,951.29	3,732,507,199.04
	Ашиглалтын зардалд төлсөн	3,048,465,985.56	2,181,691,020.42
	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	435,529,071.33	369,244,706.54
	Хүүгийн төлбөрт төлсөн	1,018,172,729.27	-
	Татварын байгууллагад төлсөн	1,357,350,804.84	2,314,301,012.94
	Даатгалын төлбөрт төлсөн	38,473,348.00	-
	Бусад мөнгөн зарлага	2,190,415,412.82	612,941,670.29
1.3	<b>Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>3,032,062,391.28</b>	<b>1,482,374,384.63</b>
<b>2</b>	<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	13,171,182.68	-
	Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгаан буцаан төлөлт	12,599,002.00	-
	Хүлээн авсан хүүний орлого	572,180.68	-
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	3,245,886,254.00	1,053,058,592.35
	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	3,166,508,854.00	913,358,592.35
	Биет бус хөрөнгө хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	79,377,400.00	139,700,000.00
	Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн	-	-
2.3	<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>(3,232,715,071.32)</b>	<b>(1,053,058,592.35)</b>
<b>3</b>	<b>Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
3.1	Мөнгөн орлогын дүн (+)	1,211,257.88	80,599,970.06
	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	-	80,599,970.06
	Бусад орлого	1,211,257.88	-
3.2	Мөнгөн зарлагын дүн	67,738,673.10	839,313,136.97
	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	31,583,897.25	675,571,436.49
	Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн	30,975,419.48	137,968,625.43
	Төлсөн ногдол ашиг	5,066,470.00	25,773,075.05

Монголын цахилгаан холбоо ХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд  
хийсэн аудитын тайлан

	Бусад зарлага	112,886.37	
3.3	<b>Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>(66,527,415.22)</b>	<b>(758,713,166.91)</b>
4	<b>Валютын ханшийн зөрүү</b>	<b>303,338.26</b>	-
5	<b>Бүх цэвэр мөнгөн гүйлгээ</b>	<b>(266,876,757.00)</b>	<b>(329,397,374.63)</b>
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	751,782,919.75	484,906,162.75
7	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	484,906,162.75	155,508,788.12

## 2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

2025 оны 12 дугаар сарын 31-ний дуусаар болсон

№	Үзүүлэлт	Х/н	2024 оны гүйцэтгэл	2025 оны		Харьцуулалт			
				Төлөвлөгөө	Гүйцэтгэл	2024 гүйц/2025 гүйц	Хувь	2025 төл/2025 гүйцэтгэл	Хувь
	Б		1	2	3	4=3-1	5	6=3-2	7
	Бүтээгдэхүүн үйлдвэрлэлт гол нэр төрлөөр:	м.төг	26,632,129.3	26,002,932.7	19,862,706.8	(6,769,422.5)	74.6	(6,140,225.9)	76.4
	Суурин утасны үйлчилгээ	м.төг	7,577,600.0	9,060,224.0	7,944,674.4	367,074.4	104.8	(1,115,549.6)	87.7
	Интернэтийн үйлчилгээ	м.төг	4386,797.4	7,561,072.7	4,445,136.1	58,338.7	101.3	(3,115,936.6)	58.8
	FTTH үйлчилгээ	м.төг	1,752,547.0	4,720,532.2	2,569,142.7	816,595.7	146.6	(2,151,389.5)	54.4
1.	Колл центр	м.төг	311,804.2	295,490.0	338,776.1	26,971.8	108.6	43,286.1	114.6
	КаТв, ОТТ, Лавлах үйлчилгээ	м.төг	1,778,999.8	1,610,427.6	1,896,890.2	117,890.4	106.6	286,462.6	117.8
	Бусад орлого	м.төг	9,824,215.8	2,265,308.8	1,766,888.1	(8,057,327.7)	18.0	498,420.6	78.0
	МТС Сервис орлого	м.төг	1,000,165.1	489,877.4	901,199.2	(98,965.9)	90.1	411,321.8	183.9
2.	Нийт орлого	м.төг	26,926,267.7	26,070,870.6	19,862,706.8	(7,063,560.9)	73.8	(6,208,163.8)	76.2
3.	Нийт зардал	м.төг	26,814,983.7	25,912,779.7	19,824,365.2	(6,990,618.5)	73.9	(6,088,414.5)	76.5
	Үүнээс: Удирдлагын зардал	м.төг	3,057,167.7	3,452,741.9	4,271,056.8	1,213,889.0	139.7	818,314.9	123.7
4.	Татварын өмнөх ашиг	м.төг	111,284.0	158,090.8	38,341.6	(72,942.4)	34.5	(119,749.2)	24.3
5.	Цэвэр ашиг /алдагдал	м.төг	58,675.8	142,281.8	8,196.5	(50,479.3)	14.0	(134,085.3)	5.8
6.	Төсвийн төлбөрт нийт дүн	м.төг	3,237,897.9	4,147,100.0	4,314,975.8	1,077,077.9	133.3	167,875.8	104.0
	а/Орлогын татварт	м.төг	-	100,000.0	50,158.2	50,158.2	-	(49,841.8)	50.2
	б/НӨАТ	м.төг	749,000.5	1,600,000.0	1,588,295.7	839,295.2	212.0	(11,704.3)	99.3
	в/НДШ	м.төг	1,880,547.1	1,850,000.0	2,076,617.0	196,069.9	110.4	226,617.0	112.2
	г/Хүн амын орлогын татвар	м.төг	569,347.9	550,000.0	549,021.3	(20,326.6)	96.4	(978.7)	99.8

Монголын цахилгаан холбоо ХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд  
хийсэн аудитын тайлан

	Д/Үл хөдлөх хөрөнгийн татвар	м.төг	21,113.9	24,000.0	33,423.8	12,309.9	158.3	9,423.8	139.3
	з/Тээврийн хэрэгслийн татвар	м.төг	2,591.3	8,100.0	15,787.5	13,196.2	609.2	7,687.5	194.9
	ж/Бусад татварт (улсын тэмдэгтийн хураамж)	м.төг	15,297.2	15,000.0	1,672.3	(13,624.9)	10.9	(13,327.7)	11.1
7.	Төрийн өмчийн ногдол ашгийн өглөг	м.төг	5,066.5	-	25,773.1	20,706.6	508.7	25,773.1	-
8.	Нийт ажиллагсдын тоо	хүн	513	690	493	(20)	96.1	(197)	71.4
9.	Нийт цалингийн сан	м.төг	7,035,445.5	8,760,468.0	8,050,331.6	1,014,886.1	114.4	(710,136.4)	91.9
10.	Нэг ажиллагчийн дундаж цалин	м.төг	1,089.8	1,058.0	1,360.8	271.0	124.9	302.8	128.6
11.	Борлуулалтын 1 төгрөгт ногдох зардал	м.төг	1	0.99	1.0	0	100.2	0	101.0
12.	Хөрөнгө оруулалт	м.төг	3,586,818.1	3,960,890.0	1,438,894.9	(2,147,923.2)	40.1	(2,521,995.1)	36.3
13.	Нийт авлага	м.төг	8,446,955.3	4,084,807.6	5,766,142.8	(2,680,812.5)	68.3	1,681,335.2	141.2
	Үүнээс: Найдваргүй	м.төг	-	-	-	-	-	-	-
	Нийт өглөг	м.төг	15,489,555.5	8,335,278.3	10,432,493.8	(5,057,061.7)	67.4	2,097,215.5	125.2
14.	Богино хугацаат ер төлбөр	м.төг	12,720,557.2	5,754,965.6	7,801,464.2	(4,919,093.0)	61.3	2,046,498.6	135.6
	Урт хугацаат ер төлбөр	м.төг	2,768,998.3	2,580,312.7	2,631,029.6	(137,968.7)	95.0	50,716.9	102.0

### 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

#### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Монголын цахилгаан холбоо ХК нь Монгол Улсын нийт нутаг дэвсгэрт улс, хот хоорондын цахилгаан холбоо, интернэт, кабелийн телевиз, лавлах үйлчилгээг хүргэх үйл ажиллагаа явуулдаг, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллага юм. Тус компанийн дүрэмд үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Иргэд, бизнес, Засгийн газрын болон бусад хэрэглэгчдэд өндөр ур чадвартай, харилцаа холбооны бүх төрлийн үйлчилгээ үзүүлэх;
- Ашиг орлогоо нэмэгдүүлэхийн тулд технологийн хөгжилтэй мөр зэрэгцэн ажиллах хувьцаа эзэмшигчиддээ үр өгөөжтэй байх;

Тус компани харилцаа холбооны үйлчилгээ, үйлчилгээний сүлжээ байгуулах, түүний ашиглалт, дэд бүтцийн суурилуулалт засвар үйлчилгээ эрхлэх 8, олон суваг дамжуулах 1, радио давтамж, радио давтамжийн зурвас ашиглах 14, нийт 23 тусгай зөвшөөрөл бүхий үйл ажиллагаа эрхэлж байна.

Компанийн улсын бүртгэлийн гэрчилгээнд төрийн өмчит хувьцаат компанийн статустай байна. Өмчийн 94.7 хувь буюу 24,499.3 мянган ширхэг хувьцааг төр буюу ТӨБЗГ, 5.3 хувь буюу 1,371.0 мянган хувьцааг 4064 хувьцаа эзэмшигч эзэмшиж байна.

#### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тус компани 1921 онд Шуудан бичиг, цахилгаан мэдээний ерөнхий газар нэртэйгээр байгуулагдаж, 1995 онд Монголын цахилгаан холбоо ХК болж 1996 оны 01 дүгээр сарын 04-нд Монголын хөрөнгийн биржид бүртгэлтэй нээлттэй хувьцаат компани болжээ.

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 дахь заалтын дагуу компанийн удирдлага болон ТУЗ-ийн бүрэлдэхүүнийг ХЭХ-ын тогтоолоор томилж байна. Монголын цахилгаан холбоо ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын 2025 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн хуралдаанаар шинэчлэн байгуулсан ТУЗ нь төрийн мэдлийн хувьцаа эзэмшигчийн төлөөлөл 6, хараат бус 3 нийт 9 гишүүний бүрэлдэхүүнтэй ажиллаж, тайлант онд 8 удаагийн хуралдаанаар 26 асуудал хэлэлцэн, 15 тогтоол, 2 тэмдэглэлээр шийдвэр гаргасан байна.

ТУЗ-ийн 2025 оны 04 дүгээр сарын 16-ны өдрийн 212 дугаар хурлын тогтоолоор компанийн зохион байгуулалтын бүтэц, орон тооны дээд хязгаарыг шинэчлэн баталсан байна. Тус компани удирдлага хүний нөөцийн, дотоод аудитын, инновац бизнес хөгжлийн, санхүү бүртгэл, аж ахуйн, техник, технологийн ашиглалтын, маркетинг борлуулалтын 6 газар, 11 алба, Мэдээллийн технологийн төв, Эм Ти Си сервис ХХК /охин компани/ болон хот, 21 аймаг, Багануур, Налайх дүүргийн холбооны газар гэсэн бүтцээр үйл ажиллагаа явуулж байна.

Компани үйл ажиллагаандаа Харилцаа холбооны тухай, Компанийн тухай, Хөдөлмөрийн тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай, Радио долгионы тухай, Өргөн нэвтрүүлгийн тухай, Кибер аюулгүй байдлын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай, Нийгмийн даатгалын тухай, Татварын багц хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай, Төрийн хэмнэлтийн тухай хууль тогтоомжийг тус тус мөрдлөг болгон ажиллаж байна.

Тайлант хугацаанд компанийн үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 3 заалтад
- Зөвшөөрлийн тухай хуулийн 2 заалтад

Компанийн удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар судалж, танилцаад гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна гэж үзсэн.

Дотоод аудитын газар нь компанийн эрсдэлийн үнэлгээ хийх, санхүү, нягтлан бодох бүртгэл, хөрөнгө оруулалт, худалдан авах ажиллагаанд хяналт, шинжилгээ, үнэлгээ хийх, шилэн дансны тайлан гаргах зэрэг 8 чиглэлээр 13 ажил хэрэгжүүлэхээр төлөвлөсний 5 нь бүрэн, 2 нь хангалтгүй, 6 нь огт хийгдээгүй гүйцэтгэл 60.0 хувьтай байна. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн чиглэлээр төлөвлөсөн 14 ажил, чанарын хяналтын албаны 3 ажил бүрэн хэрэгжсэн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Монголын цахилгаан холбоо ХК-ийн 2025 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Компанийн гүйцэтгэх захирлын 2017 оны А/72 дугаар тушаалаар баталсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад зарим талаар нийцсэн, үйл ажиллагааны онцлогт бүрэн тохирохгүй байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого ба толилуулгад орсон өөрчлөлт

Монголын цахилгаан холбоо ХК-ийн 2025 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалаар баталсан аж ахуйн нэгжид мөрдөгдөх "Санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар"-ын дагуу бэлтгэсэн байна. Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 5,528.8 сая төгрөгөөр буюу 8.6 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	484,906.2	155,508.8	(329,397.4)
Авлага	8,446,955.3	5,766,142.8	(2,680,812.5)
Бараа материал	3,212,389.5	2,651,363.1	(561,026.4)
Урьдчилж төлсөн зардал тооцоо	3,788,504.0	1,283,718.5	(2,504,785.5)
Үндсэн хөрөнгө	48,495,136.8	49,042,322.7	547,185.9
<b>Нийт хөрөнгө</b>	<b>64,427,891.8</b>	<b>58,899,055.9</b>	<b>(5,528,835.9)</b>
Богино хугацаат өр төлбөр	12,720,557.2	7,801,464.2	(4,919,093.0)
Урт хугацаат өр төлбөр	2,768,998.3	2,631,029.6	(137,968.7)
Эздийн өмч	48,938,336.3	48,466,562.1	(471,774.2)
<b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>64,427,891.8</b>	<b>58,899,055.9</b>	<b>(5,528,835.9)</b>

Дээрх хүснэгтээс харахад өмнөх оноос нөлөө бүхий өөрчлөлт гарсан дараах данстууд байна. Тухайлбал:

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 155.5 сая төгрөг болж, 329.4 сая төгрөгөөр буурсан нь орлогын харилцах данс 164.3 сая төгрөг, Эм Ти Си сервис ХХК-ийн мөнгөн хөрөнгө 108.5 сая төгрөг,

зарлагын харилцах данс 45.9 сая төгрөгөөр тус тус багассантай холбоотой байна. Арилжааны банкин дахь төгрөгийн 87, валютын 4 харилцах дансанд 147.3 сая төгрөгийн үлдэгдэлтэй.

Авлага дансны үлдэгдэл 5,766.1 сая төгрөг болж, 2,680.8 сая төгрөгөөр буурсан нь дансны авлага 3,222.4 сая төгрөгөөр буурч, татвар, нийгмийн даатгалын шимтгэлийн авлага 14.0 сая төгрөг, бусад авлага 527.5 сая төгрөгөөр тус тус өссөнөөс шалтгаалсан.

Бараа материалын дансны үлдэгдэл 2,651.4 сая төгрөг болж, 561.0 сая төгрөгөөр буурсан нь тайлант хугацаанд 4,257.4 сая төгрөгийн бараа материал нэмэгдэж, үйл ажиллагаанд 4,818.4 сая төгрөгийн бараа материал зарцуулсантай холбоотой.

Урьдчилж төлсөн зардал дансны үлдэгдэл 1,283.7 сая төгрөг болж, 2,504.8 сая төгрөгөөр буурсан нь Мэдээлэл холбооны сүлжээ ТӨХХК-д урьдчилж төлсөн 2,955.0 сая төгрөгийн сувгийн түрээсийн зардлыг тайлант онд зардлаар хүлээн зөвшөөрснөөс шалтгаалсан.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 49,042.3 сая төгрөг болж, 547.2 сая төгрөгөөр өссөн нь тайлант онд өөрийн хөрөнгөөр 1,268.7 сая төгрөгийн хөрөнгө худалдан авснаар нэмэгдэж, 2,676.1 сая төгрөгийн элэгдлийн зардлаар буурсан.

Богино хугацаат өр төлбөрийн үлдэгдэл 7,801.5 сая төгрөг болж, 4,919.1 сая төгрөгөөр буурсан нь дансны өглөг 3,087.5 сая төгрөг, бусад богино хугацаат өр төлбөр 1,333.5 сая төгрөг, татварын өр 423.7 сая төгрөгөөр тус тус буурснаас шалтгаалжээ. Богино хугацаат өр төлбөрийн 28.8 хувийг Мэдээлэл холбооны сүлжээ ТӨХХК-д өгөх талбайн түрээсийн 616.4 сая төгрөг, сүлжээ ашиглалтын 233.0 сая төгрөг, тоног төхөөрөмж байрлуулсны 485.4 сая төгрөг, түлш халаалтын 897.2 сая төгрөг, нийт 2,248.0 сая төгрөгийн өглөг эзэлж байна.

### **3.5 Зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлийн 20.1.3-д заасны дагуу Монголын цахилгаан холбоо ХК-ийн гүйцэтгэх захирал нь компанийн үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

Монголын цахилгаан холбоо ХК-ийн ТУЗ-ийн 2024 оны 12 дугаар сарын 209 дүгээр хурлын 01 дүгээр тогтоолоор 2025 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшинг баталж, нийт орлогыг 26,070.9 сая төгрөг, нийт зардлыг 25,912.8 сая төгрөг, 142.3 сая төгрөгийн ашигтай ажиллагаар тогтоож, хөрөнгө оруулалтын арга хэмжээг 3,960.9 сая төгрөгөөр баталсан байна.

#### **3.5.1 Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин**

Гүйцэтгэлээр 19,862.7 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 19,824.4 сая төгрөгийн зардал гарган, 38.3 сая төгрөгийн татварын өмнөх ашигтай ажилласан байна.

Нийт орлогын гүйцэтгэл 19,862.7 сая төгрөг болж төлөвлөснөөс 6,208.2 сая төгрөг буюу 23.8 хувиар тасарсан нь Мэдээлэл холбооны сүлжээ ТӨХХК-ийн сумдад үндсэн сүлжээний өргөтгөл хийх ажил хойшлогдсноос сумдын тоон сувгийн урсгал бүрэн нээгдээгүй нь интернэт үйлчилгээний болон гурвалсан үйлчилгээний орлого буурснаас шалтгаалжээ.

Нийт зардлын гүйцэтгэл 19,824.4 сая төгрөг болж, төлөвлөснөөс 6,088.4 сая төгрөг буюу 23.5 хувиар дутуу гүйцэтгэлтэй байгаа нь төлөвлөсөн ажил хэрэгжээгүйтэй холбоотой байна.

Хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний гүйцэтгэл 1,438.9 сая төгрөг буюу 36.3 хувьтай байна. Гүйцэтгэлээр орон нутагт шилэн кабелийн үйлчилгээ хүргэх ФТТН сүлжээ байгуулахад 842.5 сая төгрөг, нягтлан бодох бүртгэлийн програм хангамж шинээр солиход 139.5 сая төгрөг, интернэтийн сүлжээний төхөөрөмж авахад 52.4 сая төгрөг, компьютер, дагалдах хэрэгсэл авахад 29.9 сая төгрөг, КаТВ-ийн нягтруулга, хөрвүүлэгч тоног төхөөрөмжинд 135.9 сая төгрөг, агаарын шилэн кабельд 38.1 сая төгрөг, шилэн кабелийн залгааны машин,

хэмжүүрт 60.5 сая төгрөг, хөргөлт агааржуулалтын хий тэжээлийн системд 140.1 сая төгрөг зарцуулсан байна.

### **3.5.2 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл**

Монголын цахилгаан холбоо ХК-ийн ТУЗ-ийн 2024 оны 209 дүгээр хурлын 01 дүгээр тогтоолоор өгсөн эрхийн хүрээнд гүйцэтгэх захирал компанийн 2025 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг 4,272.0 сая төгрөгөөр баталсан байна.

Гүйцэтгэлээр 9 нээлттэй тендер шалгаруулалтаар 1,545.7 сая төгрөг, 12 харьцуулалтын аргаар 583.6 сая төгрөг, 11 шууд худалдан авалтын аргаар 60.7 сая төгрөг, ерөнхий гэрээгээр 2 /цахим дэлгүүр/ 29.9 сая төгрөг, нийт 2,219.9 сая төгрөгийн худалдан авалтыг хийжээ.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Монголын цахилгаан холбоо ХК-ийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийсэн компани, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Мөн тус компанийн үйл ажиллагааг сайжруулах талаар мөнгөн хөрөнгийн зарцуулалт, авлага, худалдан авах ажиллагаатай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Ниямазон аудит ХХК-ийн аудитор Т.Оюун, А.Азжаргал, аудиторын туслах М.Батцэцэг нар гүйцэтгэж, аудитын менежер Ж.Батнасан, захирал З.Цээнээ нар анхан шатны чанарын хяналтыг, Санхүүгийн аудитын газрын ахлах аудитор Д.Мөнхжин, аудитын менежер П.Чанцалдулам, газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг нар дараагийн шатны чанарын хяналтыг хэрэгжүүлсэн.

Монголын цахилгаан холбоо ХК 2025 оны санхүүгийн тайлангаа Үндэсний аудитын газарт 2026 оны 02 дугаар сарын 10-ны өдрийн 1/61 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320-д заасны дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлыг тооцох эх сурвалжийг 2024 оны орлогын дэлгэрэнгүй тайланг, суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны жилийн эцсийн орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт зардал 25,828.7 сая төгрөгөөс 1.0 хувиар буюу 258.3 сая төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор тус хуулийн 3.1.4-т “... төрийн болон орон нутгийн өмчийн 50 болон түүнээс дээш хувийн оролцоотой хуулийн этгээд, түүний албан тушаалтан” нь ТУЗ болон гүйцэтгэх захирлын хооронд байгуулах гэрээ нь нэг жилийн хугацаатай байна, санхүүгийн тайланг, аудитын дүгнэлтийн хамт, ТУЗ-ийн хараат бус гишүүний сонгон шалгаруулалттай холбоотой бүх мэдээллийг цахим хуудсанд ил тод, нээлттэй байршуулна гэснийг хэрэгжүүлж ажилласан байна.

Мөн хуулийн 12 дугаар зүйлд заасан хориглосон зардлыг санхүүжүүлээгүй, 14 дүгээр зүйлийн 14.1-д “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд заасан захиалагч нь тухайн жилд худалдан авах 10 сая төгрөгөөс дээш өртөг бүхий бараа, үйлчилгээний жагсаалтыг цахим дэлгүүрт байршуулах хүсэлтийг өмнөх онд худалдан авсан тоо хэмжээ, нэгж үнийн хамт төрийн худалдан авах ажиллагааны асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ” гэснийг хэрэгжүүлэн ажилласан байна.

### 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн асуудлаар 6,490.2 сая төгрөгийн зөрчил илэрсэнд 6,208.2 сая төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага хүргүүлж, 282.0 сая төгрөгийн зөрчилд 2 зөвлөмж өгсөн.

#### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Тус компани шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байрлуулбал зохих нийт 62 мэдээллийг хугацаанд нь иж бүрэн байрлуулсан байна.

#### 4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

##### 1. Хууль тогтоомжийн хэрэгжилт

1. ТУЗ-ийн 2024 оны 12 дугаар сарын 209 дүгээр хурлын 01 дүгээр тогтоолоор баталсан 2025 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшингийн орлогын төлөвлөгөөг 6,208.2 сая төгрөгөөр тасалсан байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 1.3-т “Үйлдвэрийн газрын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулан биелэлтийг хангах”, Монголын цахилгаан холбоо ХК-ийн ТУЗ, гүйцэтгэх захирал хоорондын онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээний 2 дугаар зүйлийн 2.1.2-т “ТУЗ-ийн шийдвэрийг хэрэгжүүлэх, компанийн үйл ажиллагааг Монгол Улсад мөрдөгдөж байгаа хууль, тогтоомжид нийцүүлэн зохион байгуулж, удирдан хяналт тавих” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Орлогын төлөвлөгөө биелүүлээгүй зөрчлийг таслан зогсоож, 2026 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшинг оновчтой төлөвлөн, биелэлтийг хангуулах арга хэмжээ авч ажиллах албан шаардлага хүргүүлэв.

##### 2. Худалдан авах ажиллагаа

1. Сонгон шалгаруулалт зохион байгуулахгүйгээр “Бараа борлуулах гэрээ” нэртэй гэрээгээр нийлүүлэгчээс төхөөрөмж авч, хэрэглэгчид түгээсэн болон төлбөр орж ирсэн эсэхийг баталгаажуулалгүйгээр үнийг бүрэн төлсөн байна. Үүнд: Дэлгэрэхбилэг ХХК-д 49.5 сая төгрөг, Гүн цэнхэр огторгуй ХХК-д 82.5 сая төгрөг, Нанар ХХК-д 150.0 сая төгрөгийг тус тус шилжүүлсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.4-т “хуульд өөрөөр заагаагүй бол бараа нийлүүлэх, ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлэх этгээдийг чөлөөт өрсөлдөөн, нээлттэй сонгон шалгаруулалтын аргаар сонгох” гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Хэрэглэгчийг төхөөрөмжөөр хангах нийлүүлэгчийг сонгон шалгаруулалтаар шалгаруулах, “Бараа борлуулах гэрээ”-нд барааг хэрэглэгчид түгээсэн, орлого төвлөрсөн эсэхийг анхан шатны баримтаар баталгаажуулсны дараа төлбөр шилжүүлэх талаар тусгах, цаашид ижил төрлийн зөрчил гаргахгүй байх зөвлөмж өгөв.

2. Тус компанийн 2025 оны худалдан авах ажиллагааны баримт бичгийг шалгахад “Шатахууны төсөл”-д тендерийн баталгааг архивлаагүй, ихэнхи тендерийн нээлтийн тэмдэглэлд ирүүлсэн болон нээсэн хугацааг тэмдэглээгүй, зарим тендерийн оролцогчоос 2024 оны санхүүгийн тайлан ирүүлэхээр шаардсан атлаа 2023 оны тайлангаар үнэлсэн, тендер шалгаруулалтын зарлалд заасан тендер нээх огноог мөрдөөгүй зөрчил илэрлээ.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ авах тухай

хуулийн 23 дугаар зүйлийн 23.1 "Захиалагч тендер хүлээн авах эцсийн хугацаа дууссанаас хойш нэг цагийн дотор тендерийг нээнэ", 27 дугаар зүйлийн 27.1-т "Захиалагч шаардлагад нийцсэн тендерийг энэ хуулийн 11.4-т үнэлгээний үндсэн шалгуурын дагуу үнэлнэ", 48 дугаар зүйлийн 48.5-д "тендер шалгаруулалтын хувийн хэргийг архивын нэгж болгон хадгална" гэсэнтэй нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Худалдан авах ажиллагааны бичиг баримтыг бүрэн архивлах, тендерийн баримт бичигт заагдсан материалд үнэлгээ хийх, тендер нээх хугацааг ягштал мөрдөх зөвлөмж өгөв.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн хүрээнд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль, тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн, бусад хууль тогтоомжийн хүрээнд илэрсэн асуудал нь холбогдох эрх зүйн актын шалгуурт нийцээгүй гэж дүгнэлээ.

#### 4.5 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар банкны шимтгэл 0.9 сая төгрөгийг бүртгэлд тусгаагүй, 1,666.8 сая төгрөгийн авлага, өглөгийн үлдэгдлийг тооцоо нийлж баталгаажуулаагүй зөрчилд 3 албан шаардлага, цалин хөлсийг нийгмийн даатгалын тайланд 164.5 сая төгрөгийн зөрүүтэй тайлагнасан зөрчилд хариуцлага тооцуулах 1 албан шаардлага, төсвийн байгууллагад 7.8 сая төгрөгийн өр төлбөртэй гарсан зөрчилд 1 зөвлөмж өгснийг хэрэгжүүлэн ажиллаж, биелэлт 100.0 хувьтай байна.


Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын хүрээнд 2.2 сая төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан зөрчилд тогтоосон төлбөрийн актыг барагдуулсан байна.

Хүснэгт 2. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт /мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитаар өгсөн		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	1	2,204.2	1	2,204.2	100.0
Албан шаардлага	3	1,667,427.9	3	1,667,427.9	100.0
Хариуцлага тооцуулах албан шаардлага	1	164,545.5	1	164,545.5	100.0
Зөвлөмж	1	7,826.2	1	7,826.2	100.0
<b>Нийт дүн</b>	<b>6</b>	<b>1,842,003.8</b>	<b>6</b>	<b>1,842,003.8</b>	<b>100.0</b>

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Монголын цахилгаан холбоо ХК-ийн бараа борлуулах гэрээний хэрэгжилт, борлуулалт, орлогын хуваарилалтын тооцоо, салбар хоорондын клирингийн тооцоог анхаарах шаардлагатай гэж үзлээ.



## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 2,871.9 сая төгрөгийн нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой 5 алдаа<sup>1</sup> илэрснийг аудитын явцад залруулсан.

*Залруулсан алдаа:* Үүнд:

- Түрээсийн авлага 487.1 сая төгрөгийг татвар, нийгмийн даатгалын шимтгэлийн авлагаар тайлагнасан;
- Түрээсийн орлого болон хүүний орлого 770.5 сая төгрөгийг ангилал зөрүүлэн тайлагнасан;
- Мэдээлэл холбооны сүлжээ ТӨХХК-д төлөх сүлжээ ашиглалтын төлбөр 233.0 сая төгрөгийг дутуу тайлагнасан;
- Голомт банкин дахь харилцах дансны үлдэгдлийг 10.0 сая төгрөгөөр илүү илэрхийлсэн;
- Мөнгөн гүйлгээний тайланд хөрөнгө оруулалтын үйл ажиллагаа, санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээг 1,371.3 сая төгрөгөөр дутуу илэрхийлсэн;

Дээрх алдааг НББОУС-8 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, нягтлан бодох бүртгэлийн тооцооллын өөрчлөлт ба алдаа стандартын 41-д "...тайлант үед илрүүлсэн уг тайлант үеийн боломжит алдааг тухайн үеийн тайланг гаргахыг зөвшөөрөхөөс өмнө засварладаг...", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-т "аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэл хөтлөлтөд гарсан алдааг алдаа гарсан шалтгаан, залруулах аргыг тодорхой тусгасан баримт, тайланг үндэслэн залруулах бөгөөд зөвшөөрсөн болон залруулга хийсэн албан тушаалтан гарын үсэг зурж баталгаажуулна", 15.2-т "нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна" гэж тус тус заасны дагуу бүрэн залруулсан.

Аудитаар нийт 327.1 сая төгрөгийн зөрчил<sup>2</sup> илэрсэнд, 9.7 сая төгрөгийн зөрчилд 2 төлбөрийн акт тогтоож, 172.1 сая төгрөгийн зөрчилд 3 албан шаардлага, 145.3 сая төгрөгийн зөрчилд 2 зөвлөмж өгсөн.

Аудитаар илрүүлсэн 327.1 сая төгрөгийн залруулагдаагүй зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 68.8 сая төгрөгөөр давсан тул "Хязгаарлалттай" дүгнэлт өгсөн.

### 5.1 Төлбөрийн акт

1. Монголын цахилгаан холбоо ХК-ийн жижиг мөнгөн сангаас анхан шатны баримтын бүрдэлгүй 6.8 сая төгрөгийг зарцуулсан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-т "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 13.7-д "анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", 20.2.5-д "... төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэсэнтэй тус тус нийцэхгүй байна.

*Шийдвэрлэсэн нь:* Анхан шатны баримтын бүрдэлгүй зарцуулсан 6.8 сая төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоов.

2. Хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмжийн хоногийг давхардуулан 10 ажилтанд 2.9 сая төгрөгийн цалин хөлс илүү олгосон байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-т "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

<sup>2</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

удирдлага хүлээнэ.”, 20 дугаар зүйлийн 20.2.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;”, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-т “Даатгуулагчийн хөдөлмөрийн чадвар түр алдсан хугацааны ажлын эхний таван өдрийн хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмжийг ажил олгогчоос, зургаа дахь өдрөөс эхлэн хөдөлмөрийн чадвар нь сэргээгдэх, эсхүл хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэвэр авах эрх үүсэх хүртэл хугацааны тэтгэмжийг тэтгэмжийн даатгалын сангаас тус тус олгоно” гэсэнтэй нийцэхгүй байна

Шийдвэрлэсэн нь: Ажилтнуудад илүү олгосон 2.9 сая төгрөгийн цалин хөлсийг тухайн ажилтнуудын цалингаас суутган төлүүлж, улсын төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоов.

## 5.2 Албан шаардлага

1. Монголын цахилгаан холбоо ХК-ийн Гүйцэтгэх захирлын 2017 оны А/71 дүгээр тушаалын 2 дугаар хавсралтаар баталсан “Жижиг мөнгөн сан, кассын үйл ажиллагааны журам”-д жижиг мөнгөн сангийн үлдэгдлийн хязгаарыг 3.0 сая төгрөгөөр тогтоосон байна. Гэтэл жижиг мөнгөн сангаас 96.3 сая төгрөгийн 16 удаагийн зарлагын гүйлгээг тогтоосон хязгаараас хэтрүүлэн хийсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.3-т “Аж ахуйн нэгж, байгууллага энэ хуулийн 14.2-т зааснаас бусад өөрийн онцлогт тохирсон дотооддоо мөрдөх анхан шатны баримт, маягтыг дүрэмдээ заасан эрх бүхий удирдах байгууллагаар батлуулан мөрдөж болно.” 18 дугаар зүйлийн 18.1-т “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ,” Компанийн тухай хуулийн 83 дугаар зүйлийн 83.1-т “Гүйцэтгэх удирдлага нь компанийн дүрэм болон ТУЗ /байхгүй бол хувьцаа эзэмшигчдийн хурал/-тэй байгуулсан гэрээнд заасан эрх хэмжээний дотор компанийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулна” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Жижиг мөнгөн санг тогтоосон хязгаарт багтаан хэрэглэж хэвшээгүй зөрчлийг таслан зогсоож, холбогдох журмын тогтоосон хязгаарт багтаан зориулалтын дагуу зөв, зохистой хэрэглэх, албан шаардлага хүргүүлэв.

2. Монголын цахилгаан холбоо ХК-ийн Голомт банкин дахь 2001004296 тоот зарлагын харилцах данснаас “уулзалтын зардал” гэх утгаар 3.9 сая төгрөгийг уулзалтын тэмдэглэлгүй, оролцогчдын мэдээлэл, хэлэлцсэн асуудлын нотлох баримтгүй, жижиг мөнгөн сангаас “үйлчилгээний төлбөр” гэх утгаар 26.5 сая төгрөгийг ямар үйлчилгээг ямар зориулалтаар авсныг нотлох баримт хавсаргалгүй тус тус зардалд бүртгэсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-т “анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан мэдээллийг үнэн зөв гаргах үндэслэл болно”, 13.4-т “Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Анхан шатны баримтгүй ажил гүйлгээг санхүүжүүлсэн зөрчлийг таслан зогсоож, хүчин төгөлдөр баримтад үндэслэн нягтлан бодох бүртгэлийг зохих ёсоор хөтөлж хэвших албан шаардлага хүргүүлэв.

3. Монголын цахилгаан холбоо ХК-ийн ТУЗ нь тайлант хугацаанд 8 удаа хуралдсан боловч гишүүдийн цалинг 12 хурлаар тооцон 45.4 сая төгрөгийг илүү олгосон байна.

Энэ нь Засгийн газрын 2023 оны 84 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд төрийн өмчийн төлөөлөл хэрэгжүүлэх журам”-ын 7.1-т “Төрийн өмчит компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүний ... цалин хөлсийг цагаар тооцож олгоно”, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2023 оны 174 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн өмчит компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүний цалин хөлсний хэмжээг тооцох оролцоонд суурилсан холимог аргачлал”-ын 2.3.1-

т “ТУЗ-ийн хуралдаанд оролцсон хурал тутамд ... суурь цалинг тооцно” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: ТУЗ-ийн гишүүдийн цалин хөлсийг илүү олгодог зөрчлийг таслан зогсоож, цалинг холбогдох журам, аргачлалын дагуу тооцон олгох албан шаардлага хүргүүлэв.

### **5.3 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав.

#### **1. Авлагатай холбоотой асуудал**

##### Илрүүлэлт:

Арваас дээш жилийн насжилттай сувгийн түрээсийн 117.8 сая төгрөг, интернэт хэрэглэгчийн авлага 11.3 сая төгрөгийн авлагыг барагдуулах арга хэмжээ авч ажиллаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-т “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ” гэж заасантай нийцэхгүй байна.

##### Өгсөн зөвлөмж:

Авлагыг насжилтаар нь дахин ангилж, хариуцагчийг тодорхойлох, албан мэдэгдэл хүргүүлэх, найдваргүй авлагын сан байгуулах, удаан хугацаанд барагдуулах боломжгүй гэж үзсэн авлагыг холбогдох эрх бүхий байгууллагаар шийдүүлэх арга хэмжээ авч ажиллах

#### **2. Бараа материалтай холбоотой асуудал**

##### Илрүүлэлт:

Тайлант хугацаанд 16.2 сая төгрөгийн бараа материалыг ибаримтгүй худалдан авсан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-т “анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн зөв гаргах үндэслэл болно”, Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйлийн 28.5-д “Татвар төлөгч борлуулалт хийх тухай бүрд хэрэглэгчийн системээс дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримтыг хэвлэж өгөх, эсхүл цахимаар илгээх үүрэгтэй” гэж заасантай нийцээгүй, санхүүгийн тайлагналын үнэлгээ ба хуваарилалт, толилуулга батламж мэдэгдлийг хангаагүй байна” гэж заасантай нийцэхгүй байна.

##### Өгсөн зөвлөмж:

Анхан шатны баримтын бүрдүүлэлтийг хангаж, ибаримтыг худалдан авалт бүрт авч хэвших

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Үндэсний аудитын газарт 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

**6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ**

**Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл**

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй	
							Тоо	Дүн	Тоо	Дүн
Түрээсийн авлагыг татвар, нийгмийн даатгалын шимтгэлийн авлагаар тайлагнасан.	1	487,126.0			1	487,126.0	1	487,126.0		
Орлогын дэлгэрэнгүй тайланд түрээсийн болон хүүний орлогыг ангилал зөрүүтэй тайлагнасан	1	770,445.4			1	770,445.4	1	770,445.4		
Сүлжээ ашиглалтын төлбөрийн өглөгийг дууу тусгасан	1	233,000.0	1	233,000.0			1	233,000.0		
Харилцах дансны үлдэгдлийг зөрүүтэй илэрхийлсэн	1	10,000.0	1	10,000.0			1	10,000.0		
Мөнгөн гүйлгээний тайланд хөрөнгө оруулалтын болон санхүүгийн үйл ажиллагааны гүйлгээг дууу илэрхийлсэн	1	1,371,293.1			1	1,371,293.1	1	1,371,293.1		
<b>Дүн</b>	<b>5</b>	<b>2,871,864.5</b>	<b>2</b>	<b>243,000.0</b>	<b>3</b>	<b>2,628,864.5</b>	<b>5</b>	<b>2,871,864.5</b>		

/Мянган төгрөгөөр/



Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	/мянган төгрөгөөр/											
	Нийт зөрчил		Төлбөрийн акт				Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Арваас дээш жилийн насжилттай сувгийн түрээс болон интернэт хэрэглэгчийн авлага барагдуулах арга хэмжээ аваагүй	1	129,095.5							1	129,095.5		
Жижиг мөнгөн сангийн үлдэгдлийн хязгаарыг зөрчиж 16 удаагийн зарлагын гүйлгээг хэтрүүлэн хийсэн	1	96,263.5			1	96,263.5						
Жижиг мөнгөн сангаас анхан шатны баримтын бүрдэлгүй зарцуулсан	1	6,788.9	1	6,788.9								
Харилцах данс болон жижиг мөнгөн сангаас "уулзалтын зардал", "үйлчилгээний төлбөр" утгаар хийгдсэн гүйлгээний зориулалтыг нотлох баримтгүй	1	30,428.6			1	30,428.6						
Хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмжийн хоногийг давхардуулан 10 ажилтанд цалин хөлс илүү олгосон	1	2,907.7	1	2,907.7								
ТУЗ нь тайлант хугацаанд 8 удаа хуралдсан боловч 12 хурлаар тооцон гишүүдийн цалинг илүү олгосон	1	45,440.0			1	45,440.0						
Бараа материалыг ибаримтгүй худалдан авсан	1	16,208.3							1	16,208.3		
<b>Дүн</b>	<b>7</b>	<b>327,132.5</b>	<b>2</b>	<b>9,696.6</b>	<b>3</b>	<b>172,132.1</b>	<b>2</b>	<b>145,303.8</b>				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Үүнээс Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
	/Мянган төгрөгөөр/							
<b>Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил</b>								
ТУЗ-ийн 2024 оны 12 дугаар сарын 209 дүгээр хурлаар баталсан 2025 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшингийн орлогын төлөвлөгөөг тасалсан	1	-			1	-		
Сонгон шалгаруулалт зохион байгуулахгүйгээр "Бараа борлуулах гэрээ" нэртэй гэрээгээр нийлүүлэгчээс төхөөрөмж авч, хэрэглэгчид түгээсэн болон төлбөр орж ирсэн эсэхийг баталгаажуулалгүйгээр үнийг бүрэн төлсөн байна. Үүнд: Дэлгэрэхбилэг ХХК-д 49.5 сая төгрөг, Гүн цэнхэр огторгуй ХХК-д 82.5 сая төгрөг, Нанар ХХК-д 150.0 сая төгрөгийг тус тус шилжүүлсэн байна.	1	-					1	-
2025 оны худалдан авах ажиллагааны баримт бичгийг шалгахад "Шатахууны төсөл"-д тендерийн баталгааг архивлаагүй, инэнхи тендерийн нээлтийн тэмдэглэлд ирүүлсэн болон нээсэн хугацааг тэмдэглээгүй, зарим тендерийн оролцогчоос 2024 оны санхүүгийн тайлан ирүүлэхээр шаардсан атлаа 2023 оны тайлангаар үнэлгээ хийсэн, тендер шалгаруулалтын зарлалд заасан тендер нээх хугацааг мөрдөөгүй	1	-					1	-
<b>Дүн</b>	<b>3</b>	<b>-</b>			<b>1</b>	<b>-</b>	<b>2</b>	<b>-</b>



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АКТ

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 175/А0150061

Улаанбаатар хот

САГ - 2026/54/НА - СТА - ТӨҮГ

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Монголын цахилгаан холбоо ХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Монголын цахилгаан холбоо ХК-ийн жижиг мөнгөн сангаас анхан шатны баримтын бүрдэлгүй 6,788,871.00 (зургаан сая долоон зуун наян найман мянга найман зуун далан нэгэн) төгрөгийг зарцуулсан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 13.7-д "анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", 20.2.5-д "... төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэсэнтэй тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгаагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.3.8-д "Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т заасан бусад нөхцөл байдал үүссэн"-д заасныг үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Анхан шатны баримтын бүрдэлгүй зарцуулсан 6,788,871.00 (зургаан сая долоон зуун наян найман мянга найман зуун далан нэгэн) төгрөгийг ерөнхий нягтлан бодогч Т.Халиунаагаар нөхөн төлүүлж, Үндэсний аудитын газрын Төрийн сан банкин дахь Аудитын шалгалтын орлого 100900000601 тоот дансанд төвлөрүүлэх;
2. Актын биелэлтийг 2026 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Монголын цахилгаан холбоо ХК-ийн гүйцэтгэх захирал /Б.Чинбат/-д хариуцуулав.

**ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:**

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
НИЯМАЗОН АУДИТ ХХК-ИЙН  
ЗАХИРАЛ



Ц.НАРАНЧИМЭГ  
П.ЧАНЦАЛДУЛАМ

3.ЦЭЭНЭЭ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АКТ

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 176/А0150061

Улаанбаатар хот

САГ-2026/54/МА -СТА-ТӨҮГ

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Монголын цахилгаан холбоо ХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмжийн хоногийг давхардуулан 10 ажилтанд 2,907,728.00 (хоёр сая есөн зуун долоон мянга долоон зуун хорин найман) төгрөгийн цалин хөлс илүү олгосон.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ.", 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах," Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-т "Даатгуулагчийн хөдөлмөрийн чадвар түр алдсан хугацааны ажлын эхний таван өдрийн хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмжийг ажил олгогчоос, зургаа дахь өдрөөс эхлэн хөдөлмөрийн чадвар нь сэргээгдэх, эсхүл хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэвэр авах эрх үүсэх хүртэл хугацааны тэтгэмжийг тэтгэмжийн даатгалын сангаас тус тус олгоно" гэсэнтэй нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгагдагч этгээд төсөө, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.3.3-т "цалин хөлс, шагнал урамшуулал, тэтгэмжийг зөрүүтэй тооцож олгосон"-д заасныг үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Ажилтнуудад илүү олгосон 2,907,728.00 (хоёр сая есөн зуун долоон мянга долоон зуун хорин найман) төгрөгийн цалин хөлсийг тухайн ажилтнуудын цалингаас суутган төлүүлж, Үндэсний аудитын газрын Төрийн сан банкин дахь Аудитын шалгалтын орлого 100900000601 тоот дансанд төвлөрүүлэх;
2. Актын биелэлтийг 2026 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Монголын цахилгаан холбоо ХК-ийн гүйцэтгэх захирал /Б.Чинбат/, ерөнхий нягтлан бодогч /Т.Халиунаа/ нарт хариуцуулав.

**ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:**

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
НИЯМАЗОН АУДИТ ХХК-ИЙН  
ЗАХИРАЛ



Ц.НАРАНЧИМЭГ  
П.ЧАНЦАЛДУЛАМ

З.ЦЭЭНЭЭ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 202-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,  
Утас 51-264230

Z:\Akt\2026\0316 SAG-30.Docx

1526200231



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 819/АД150061

Улаанбаатар хот

САГ-2026/54/НА-СТА-ТВҮГ

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Монголын цахилгаан холбоо ХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Монголын цахилгаан холбоо ХК-ийн Голомт банкин дахь 2001004296 тоот зарлагын харилцах данснаас "уулзалтын зардал" гэх утгаар 3,913,700.00 (гурван сая есөн зуун арван гурван мянга долоон зуун) төгрөгийг уулзалтын тэмдэглэлгүй, оролцогчдын мэдээлэл, хэлэлцсэн асуудлын нотлох баримтгүй, жижиг мөнгөн сангаас "үйлчилгээний төлбөр" гэх утгаар 26,514,876.0 (хорин зургаан сая таван зуун арван дөрвөн мянга найман зуун далан зургаан) төгрөгийг ямар үйлчилгээг ямар зориулалтаар авсныг нотлох баримт хавсаргалгүй тус тус зардалд бүртгэсэн байна.

Энэ нь "Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д "анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан мэдээллийг үнэн зөв гаргах үндэслэл болно", 13.4-т "Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгаагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.1-д "нягтлан бодох бүртгэлийг холбогдох стандарт, хууль тогтоомжийн дагуу зохих ёсоор хөтөлж, баталгаажуулаагүй" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ НЬ:**

1. Анхан шатны баримтгүй ажил гүйлгээг санхүүжүүлсэн зөрчлийг таслан зогсоож, хүчин төгөлдөр баримтад үндэслэн нягтлан бодох бүртгэлийг зохих ёсоор хөтөлж хэвших, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Монголын цахилгаан холбоо ХК-ийн гүйцэтгэх захирал /Б.Чинбат/, ерөнхий нягтлан бодогч /Т.Халиунаа/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
НИЯМАЗОН АУДИТ ХХК-ИЙН  
ЗАХИРАЛ



Ц.НАРАНЧИМЭГ  
П.ЧАНЦАЛДУЛАМ

Э.ЦЭЭНЭЭ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 91-р хороо, Бага тайруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

Z:\Alban Shaardlaga\20260316 SAG-55.Docx

1526181115



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 820/A0150061

Улаанбаатар хот

САГ-2026/54/НА-СТА-ТӨҮГ

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Монголын цахилгаан холбоо ХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Монголын цахилгаан холбоо ХК-ийн Гүйцэтгэх захирлын 2017 оны А/71 дүгээр тушаалын 2 дугаар хавсралтаар баталсан "Жижиг мөнгөн сан, кассын үйл ажиллагааны журам"-д жижиг мөнгөн сангийн үлдэгдлийн хязгаарыг 3,000,000.00 /гурван сая/ төгрөгөөр тогтоосон байна. Гэтэл жижиг мөнгөн сангаас 96,263,485.00 /ерэн зургаан сая хоёр зуун жаран гурван мянга дөрвөн зуун наян таван/ төгрөгийн 16 удаагийн зарлагын гүйлгээг тогтоосон хязгаараас хэтрүүлэн хийсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.3-т "Аж ахуйн нэгж, байгууллага энэ хуулийн 14.2-т зааснаас бусад өөрийн онцлогт тохирсон дотооддоо мөрдөх анхан шатны баримт, маягтыг дүрэмдээ заасан эрх бүхий удирдах байгууллагаар батлуулан мөрдөж болно." 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ," Компанийн тухай хуулийн 83 дугаар зүйлийн 83.1-д "Гүйцэтгэх удирдлага нь компанийн дүрэм болон төлөөлөн удирдах зөвлөл /байхгүй бол хувьцаа эзэмшигчдийн хурал/-тэй байгуулсан гэрээнд заасан эрх хэмжээний дотор компанийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулна" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.11-д "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ НЬ:**

1. Жижиг мөнгөн санг тогтоосон хязгаарт багтаан хэрэглэж хэвшээгүй зөрчлийг таслан зогсоож, холбогдох журмын тогтоосон хязгаарт багтаан зориулалтын дагуу зөв, зохистой хэрэглэх, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Монголын цахилгаан холбоо ХК-ийн гүйцэтгэх захирал /Б.Чинбат/, ерөнхий нягтлан бодогч /Т.Халиунаа/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
НИЯМАЗОН АУДИТ ХХК-ИЙН  
ЗАХИРАЛ



Ц.НАРАНЧИМЭГ  
П.ЧАНЦАЛДУЛАМ  
В.ЦЭЭНЭЭ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 821/А0150061

Улаанбаатар хот

САГ-2026/54/НА-СТА-ТӨҮГ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Монголын цахилгаан холбоо ХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Монголын цахилгаан холбоо ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл нь тайлант хугацаанд 8 удаа хуралдсан боловч гишүүдийн цалинг 12 хурлаар тооцон 45,440,000.00 (дөчин таван сая дөрвөн зуун дөчин мянган) төгрөгийг илүү олгосон байна.

Энэ Засгийн газрын 2023 оны 84 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд төрийн өмчийн төлөөлөл хэрэгжүүлэх журам"-ын 7.1-д "Төрийн өмчит компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүний ... цалин хөлсийг цагаар тооцож олгоно", Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2023 оны 174 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн өмчит компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүний цалин хөлсний хэмжээг тооцох оролцоонд суурилсан холимог аргачлал"-ын 2.3.1-т "Төлөөлөн удирдах зөвлөлийн хуралдаанд оролцсон хурал тутамд ... суурь цалинг тооцно" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.11-д "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ НЬ:**

1. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн цалин хөлсийг илүү олгодог зөрчлийг таслан зогсоож, цалинг холбогдох журам, аргачлалын дагуу тооцон олгох, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Монголын цахилгаан холбоо ХК-ийн гүйцэтгэх захирал /Б.Чинбат/, ерөнхий нягтлан бодогч /Т.Халиунаа/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
НИЯМАЗОН АУДИТ ХХК-ИЙН  
ЗАХИРАЛ



Ц.НАРАНЧИМЭГ  
П.ЧАНЦАЛДУЛАМ

В.ЦЭЭНЭЭ

1526181117



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 822/АД/50061

Улаанбаатар хот

САГ - 2026/54/НА - С ТА - ТӨҮГ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Монголын цахилгаан холбоо ХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Монголын цахилгаан холбоо ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны 12 дугаар сарын 209 дүгээр хурлын 01 дүгээр тогтоолоор баталсан 2025 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшингийн орлогын төлөвлөгөөг 6,208,163,800.00 (зургаан тэрбум хоёр зуун найман сая нэг зуун жаран гурван мянга найман зуун) төгрөгөөр тасалсан байна.

Энэ Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 1.3-т "Үйлдвэрийн газрын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулан биелэлтийг хангах", Монголын цахилгаан холбоо ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх захирал хоорондын онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээний 2 дугаар зүйлийн 2.1.2-т "ТУЗ-ийн шийдвэрийг хэрэгжүүлэх, компанийн үйл ажиллагааг Монгол Улсад мөрдөгдөж байгаа хууль, тогтоомжид нийцүүлэн зохион байгуулж, удирдан хяналт тавих" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгаагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.11-д "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ НЬ:**

- Орлогын төлөвлөгөө биелүүлээгүй зөрчлийг таслан зогсоож, 2026 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшинг оновчтой төлөвлөн, биелэлтийг хангуулах арга хэмжээ авч ажиллах, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
- Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Монголын цахилгаан холбоо ХК-ийн гүйцэтгэх захирал /Б.Чинбат/, ерөнхий нягтлан бодогч /Т.Халиунаа/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
НИЯМАЗОН АУДИТ ХХК-ИЙН  
ЗАХИРАЛ



Ц.НАРАНЧИМЭГ  
П.ЧАНЦАЛДУЛАМ  
З.ЦЭЭНЭЭ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,  
Утас 51-264230

Z:\Alban Shaardlaga\20260316 SAG-55.Docx

1526181119





Утас: +976 51 261585  
Факс: +976 11 323266, 324653

Цахим шуудан: [info@audit.gov.mn](mailto:info@audit.gov.mn)  
Цахим хуудас: [www.audit.mn](http://www.audit.mn)

Хаяг: Засгийн газрын IV байр  
Бага тойруу-3, Чингэлтэй дүүрэг